



ОРХОН АЙМГИЙН
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 10/05

Баян-Өндөр сум

Таеквондогийн бага нас, өсвөрийн аймгийн
аварга шалгаруулах тэмцээнд хөрөнгө
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Таеквондогийн спортын 2025 оны аймгийн аварга шалгаруулах тэмцээнд зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

2.Тэмцээнийг зохион байгуулах, санхүүжүүлэх гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг спортын хэлтсийн дарга (Э.Лхамсүрэнбаатар), өсвөрийн шигшээ баг, боловсролын байгууллагын спортын асуудал, сургалт, дасгалжуулалт хариуцсан мэргэжилтэн (М.Сэргэлэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тэмцээнд зарцуулагдах 810,000 (найман зуун арван мянга) төгрөгийг зохих журмын дагуу үндэсний тэмцээн наадмын үйл ажиллагааны зардлаас гаргаж, гэрээний дагуу шилжүүлэг хийхийг ерөнхий нягтлан бодогч, аж ахуйн албаны дарга (Ж.Нямжаргал)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.ДЭЛГЭРБАЯР

Биеийн тамир, спортын газрын даргын
2025 оны 01 дугаар сарын 31-ны өдрийн
10/05 дугаар тушаалын хавсралт

ТАЕКВОНДОГИЙН ӨСВӨР ҮЕИЙН 2025 ОНЫ АЙМГИЙН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Медаль	60	11,000	660,000
2	Өргөмжлөл	60	2,500	150,000
Төсвийн нийт дүн				810,000

----oOo----